



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны гудамж 136, Утас: 7012 8801,
Факс: (976) 32 06 33, И-мэйл: admin@hdc.gov.mn,
Вэбсайт: www.hdc.gov.mn

2023.02.28 № 154
танай _____-ны № _____-т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР БОЛОН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАРТ**

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг
бүртгэх, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн
сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан
маягтын дагуу төв болон тусгай мэргэжлийн төв
эмнэлгүүдээс 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн
байдлаар ирүүлсэн мэдээг нэгтгэн хүргүүлж байна.
Хүлээн авч танилцана уу.

Хавсралт 5 хуудас.

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

14~200000538

**Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн
хүлээгдлийн мэдээний нэгтгэл**

/2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар/

1. Хавдар судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмчийн үзлэг хийлгэхээр нийт 474 үйлчлүүлэгч 2-с дээш хоногоор хүлээж байгаа нь 2023 оны 1 сараас 77 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 94% /445/ нь 7 ба түүнээс дээш хоногоор хүлээгдэлтэй байна. /Хүснэгт 1/.

**Хүснэгт 1 . Хавдар судлалын үндэсний төвийн амбулаторийн
хүлээгдэл**

№	Үзлэгийн кабинетын нэр	Амбулаториор үзүүлэхээр хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо		Бүгд
		4-6 хоног	7-с дээш хоног	
1	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	106	106
2	Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал	6	53	59
3	Хими	-	56	56
4	Толгой, хүзүүний мэс засал	-	-	55
5	Хөхний төв	1	45	46
6	Ерөнхий мэс засал	-	36	36
7	Зүрх судас судлал	22	11	33
8	Туяа эмчилгээ	-	30	30
9	Ангиографи	-	27	27
10	Элэг судлал	-	17	17
11	Цээжний хөндийн мэс засал	-	6	6
12	Сэргээн засах	-	3	3
	Нийт	29	445	474

Эмэгтэйчүүдийн мэс засалд үзүүлэхээр 106, Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын эмчид үзүүлэхээр 56, Хими эмчилгээний зүлэгт орохоор 56, Толгой, хүзүүний мэс заслын эмчид үзүүлэхээр 55 үйлчлүүлэгч 4 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн үзлэгт хамаарч байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 4-с дээш хоногоор нийт 112 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ойролцоо байна. КТГ-ийн оношилгоо хийлгэхээр 37, ходоод дурандуулахаар 26 хүн тус бүр 7-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарна. Эход харуулахаар 17, хөхний зураг авахуулахаар 16, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 13 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна.

ХСҮТ-ийн лаборатори хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ их хүлээгдэлтэй, нийт 523 үйлчлүүлэгч хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй ойролцоо байна. /Хүснэгт 2/.

Хүснэгт 2 . Хавдар судлалын үндэсний төвийн орны хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Өдрийн хими	7	80	140	41	268
2	Хими	1	24	47	30	102
3	Ангиографи	-	4	36	7	47
4	Элэг, цэс, нойр булчирхайн мэс засал	4	7	9	9	29
5	Хөнгөвчлөх	-	6	18	2	26
6	Эмэгтэйчүүдийн мэс засал	-	9	2	2	13
7	Ерөнхий мэс засал	1	-	7	1	9
8	Туяа	1	1	4	2	8
9	Толгой, хүзүүний мэс засал	3	-	1	3	7
10	Хөхний төв	5	1	1	-	7
11	Дуран	-	2	1	1	4
12	Цээжний хөндийн мэс засал	-	-	3	-	3
	Нийт	22	134	269	98	523

Тус эмнэлэгт өдрийн болон хими эмчилгээ хийлгэхээр нийт 370 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь 1 сарын үзүүлэлтээс даруй 45 үйлчлүүлэгчээр нэмэгджээ. Хүлээгдэл нэмэгдэхэд үйлчлүүлэгчид 14-21 хоногийн давтамжтай товлот хими эмчилгээ хийдэг нь нөлөөлсөн байна. Ангиографиийн тасагт хэвэхээр 47 үйлчлүүлэгч, Элэг, цэс, нойр булчирхайн мэс заслын тасагт хэвтэхээр 29 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь удаах хамгийн их хүлээгдэлтэй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээнд орж байна.

2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээ бараг хүлээгдэлгүй байна. Чих, хамар, хоолойн мэргэжлийн эмчид үзүүлэхээр 2 үйлчлүүлэгч 7-с дээш хоног, Булчирхайн эмчид үзүүлэхээр 1 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байна.

Оношилгооны чиглэлээр тусламж, үйлчилгээ хүлээгдэлгүй ажиллаж байна. Харин хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд маш их хүлээгдэлтэй, нийт 1537 үйлчлүүлэгч ор хүлээж байна. /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Чих, хамар, хоолойн тасаг	3-6 хоног	30
		7-14 хоног	50
		15-30 хоног	195
		1 сараас дээш	443
	Нийт		718

2	Нүдний тасаг	3-6 хоног	1
		7-14 хоног	15
		15-30 хоног	55
		1 сараас дээш	200
	Нийт		271
3	БШГМЗ тасаг	3-6 хоног	6
		7-14 хоног	50
		15-30 хоног	40
		1 сараас дээш	125
	Нийт		221
4	Мэс заслын тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	70
		15-30 хоног	80
		1 сараас дээш	4
	Нийт		161
5	Урологийн тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	30
		15-30 хоног	38
		1 сараас дээш	0
	Нийт		88
6	Зүрх судас судлал	7-14 хоног	8
		15-30 хоног	9
		1 сараас дээш	2
	Нийт		19
7	Дотоод шүүрэл судлал	3-6 хоног	2
		7-14хоног	11
		15-30 хоног	5
		1 сараас дээш	0
	Нийт		18
8	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	2
		7-14хоног	11
		15-30 хоног	3
		1 сараас дээш	0
	Нийт		16
9	Цусны эмгэг судлал	3-6 хоног	2
		7-14хоног	8
		15-30 хоног	4
		1 сараас дээш	0
	Нийт		14
10	Бөөр судлал	3-6 хоног	2
		7-14хоног	2
		15-30 хоног	2
	Нийт		6
11	Уушиг судлал	3-6 хоног	0
		7-14 хоног	2
	Нийт		2
12	Мэдрэл судлал	15-30 хоног	2
	Нийт		2
	БҮГД	3-6 хоног	72
		7-14хоног	258

		15-30 хоног	433
		1 сараас дээш	774
	НИЙТ		1537

Чих хамар хоолойн тасагт хэвтэхээр нийт 718 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь эмнэлгийн хэмжээнд нийт орны хүлээгдлийн бараг тал хувийг / 47%/ эзэлж байгаа ба 718 үйлчлүүлэгчийн талаас илүү буюу 62% нь 1 сар ба түүнээс дээш хугацаагаар хүлээгдэлтэй байна. Мөн Нүдний тасагт хэвтэж эмчлүүлэхээр 271 үйлчлүүлэгч хүлээж байгаагийн дийлэнх буюу 74% /200/ нь 1 сараас дээш хоногоор ор хүлээж байна.

3. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ өмнөх саруудтай харьцуулахад хүлээгдэл багатай байна. Нийт 62 үйлчлүүлэгч амбулаторийн 7 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 7-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлтээс 83 үйлчлүүлэгчээр буурсан байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлал, Мэс засал судлалын эмчийн үзлэг орж байна./Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хоног	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	7-с дээш хоног	24
	НИЙТ		24
2	Мэс засал судлал	7-с дээш хоног	10
	НИЙТ		10
3	Уламжлалт анагаах ухаан судлал	7-с дээш хоног	10
	НИЙТ		10
4	Бөөр судлал	4-6 хоног	1
		7-с дээш хоног	7
	НИЙТ		8
5	Мэдрэл судлал	7-с дээш хоног	7
	НИЙТ		7
6	Нүд судлал	7-с дээш хоног	2
	НИЙТ		2
7	Эмэгтэйчүүд судлал	7-с дээш хоног	1
	НИЙТ		1
	БҮГД	4-6 хоног	1
		7-с дээш хоног	61
	НИЙТ		62

Оношилгоо хийлгэхээр нийт 57 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа ба рентген зураг авахуулахаар 24, эхо оношилгоо хийлгэхээр 19, MRI/CT оношлогоо хийлгэхээр 13 үйлчлүүлэгч 3-аас дээш хоног хүлээж байна. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн лабораторийн шинжилгээ харьцангуй хүлээгдэлтэй, шинжилгээ хийлгэхээр 3-с дээш хоног хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо 94-д хүрч, 2023 оны 1

сараас даруй 74 хүнээр өссөн байна. Биохимийн шинжилгээ хийлгэхээр 77 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаагийн ихэнх буюу 70% /54/ нь 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Үлдсэн 23 үйлчлүүлэгч биохимийн шинжилгээ хийлгэхээр 7-14 хоног хүлээж байна.

Тус эмнэлэг орны хүлээгдэл ихтэй байна. Тус эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхээр нийт 406 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 243 үйлчлүүлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Мэс заслын тасаг хамгийн их хүлээгдэлтэй, уг тасагт хэвтэн эмчлүүлэхээр 180 үйлчлүүлэгч ор хүлээж байна Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	
1	Мэс засал судлал	78	102	-	180
2	Чих, хамар, хоолой судлал		47	48	95
3	Хоол боловсруулах эрхтэн судлал	28	12	33	73
4	Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасаг	8	13	8	29
5	Бөөрний мэс засал судлал	8	3	-	11
6	Зүрх судасны эмгэг судлал	8	2	-	10
7	Мэдрэл судлал	6	-	-	6
8	Уушиг судлал	2	-	-	2
	НИЙТ	138	179	89	406

Хэвтүүлэн эмчлүүлэхээр хүлээж байгаа үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 78% /317/ нь 2 долоо хоног хүртэл хугацаагаар ор хүлээж байна.

4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

Тус төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл 1 сараас 2 дахин ихэссэн үзүүлэлттэй байна. Эмгэг сэтгэл судлалын үзлэгт хамрагдахаар 114 үйлчлүүлэгч 7-14 хоног хүлээж байна. Харин стрессийн шалтгаант сэтгэцийн эмгэг судлалын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 81 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байгаа нь 1 сарын үзүүлэлтээс 30 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

5. Хүрээ амаржих газар ТМЭ, АӨСҮТ, Геронтологийн үндэсний төв нь 2023 оны 2 дугаар сард хүлээгдэлгүй ажиллаж байна.
6. ШУГТЭ, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, ГССҮТ, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.